



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЫН  
ТОГТООЛ

2024 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 24/21

Улаанбаатар хот

Барилга байгууламж акталж, нийслэлийн  
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 80 дугаар зүйлийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр 200 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга баригдах болсонтой холбогдуулан Сүхбаатар дүүрэгт байрлах 16 дугаар цэцэрлэгийн баланст бүртгэлтэй нийт 14,233,300.00 (арван дөрвөн сая хоёр зуун гучин гурван мянга гурван зуу) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 8,572,052.50 (найман сая таван зуун далан хоёр мянга тавин хоёр төгрөг тавин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 5,661,247.50 (таван сая зургаан зуун жаран нэгэн мянга хоёр зуун дөчин долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй хавсралтад дурдсан тус цэцэрлэгийн хуучин барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсөв, хөрөнгө оруулалтын хороо (Ж.Сандагсүрэн)-нд даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

1110101054

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн  
 21/21 дүгээр тогтоолын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,  
 НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр	Хүчин чадал	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Бүртгэлийн үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2024.10.01/	Үлдэгдэл өртөг
1	Агуулахын барилга	м2	66	2011	5,783,400.00	554,252.50	5,229,147.50
2	Узелийн барилга	м2	30,12	1970	8,017,800.00	8,017,800.00	-
3	Бут	ш	72	1996	432,100.00	-	432,100.00
	НИЙТ ДУН				14,233,300.00	8,572,052.50	5,661,247.50